

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан 2018



АГУУЛГА

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Групп компанийн бүтэц
- Компаниудын танилцуулга
- Бүтээгдэхүүний багцын танилцуулга
- Хагас жилийн үйл ажиллагааны тойм

УДИРДЛАГЫН БАГ

- Төлөөлөн удирдах зөвлөлийн баг
- Гүйцэтгэх удирдлагын баг

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ


- Санхүүгийн тайлан
- Зээлийн мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

- Хувьцаа эзэмшигчид
- Хувьцааны арилжаа
- Зах зээлийн үнэлгээ

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

- Ногдол ашиг





АПУ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

АПУ ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

Өнгөрсөн 2017 онд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй шингэн хүнсний салбарт томоохон орон зайг эзэлдэг АПУ ХК болон МВС компаниуд нэгдэж нэгэн шинэ түүхийн хуудсыг бичиж байсан цаг саяхан. Өнөөдөр уг хоёр компанийн олон арван алба нэгжүүд ажил үүргээрээ болон сэтгэл зүрхээрээ “НЭГ ГЭР БҮЛ” болж “НЭГ ЗОРИЛГО” -тойгоор эвлэлдэн нэгдэж ажиллаж буйд гүйцэтгэх удирдлагын зүгээс баяртай байна. Нэгдлийн хүрээнд хүний хөгжлийг дээдэлж, олон улсын засаглалын менежментийг нэвтрүүлж, гадаад зах зээлд экспортыг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байгаа билээ.


Тухайлбал нэг соёл, нэгдмэл үзэл санааг бий болгох зорилгоор “Төгөлдөр” төслийн хүрээнд Нэгдсэн сар шинийн золголт, “APU Olympics 2018” спорт наадам, ОУ-ын эмэгтэйчүүдийн баярын үйл ажиллагаа, “APU гэр бүлийн өдөр” зэрэг олон арван ажлуудыг санаачилж, хэрэгжүүлжээ. Мөн 2018 онд ажиллах шинэ удирдлагын багийг томилж, эрх үүргийн хуваарилалтыг хийж, шинэ дүрэм журмуудыг олон улсын зөвлөх “Bain & Company”-ийн тусламжтайгаар амжилттай нэвтрүүлж буйг дуулгахад таатай байна. Экспортын хувьд ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Япон, БНСУ зэрэг орнууд руу бүтээгдэхүүнээ худалдан борлуулж байгаа бөгөөд саяхан ОХУ-ын Буриадын Автономит улстай худалдааны чиглэлээр төрийн өндөр албан тушаалтнуудтай санал солилцож, яриа хэлэлцээрийг эхлүүлээд байна.

2018 оны хагас жилийн байдлаар АПУ ХК нь нийт 2,202 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа тогтмол явуулж, 278 нэр төрлийн 65 сая литр бүтээгдэхүүнийг борлуулж, 201 тэрбум төгрөгийн орлого олж, 33.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Мөн тайлант үеийн байдлаар улсын төсөвт нийт 120 тэрбум төгрөгийн татварыг төлсөн байна.

АПУ ХК-ийн ололт амжилт бүрийн ард эрхэм хувьцаа эзэмшигч, харилцагч та бүхэн байдаг бөгөөд бидэнд өгсөн итгэл, өндөр хариуцлагыг бүрэн ухамсарлаж үйл хэрэг болгон ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Та бүхэн энэ түүхэн цаг үед бид бүхэнтэй нэгэн сэтгэлээр хамт байж, нэгдмэл хүчээр ХАМТ ДАА ИЛҮҮ ХҮЧТЭЙ хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



КОМПАНИУДЫН ТАНИЛЦУУЛГА





ДЕПОД ХХК

Депод ХХК-нь 2008 онд байгуулагдсан бөгөөд байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжин бүтээгдэхүүний шилийг цуглуулж үйлдвэрт нийлүүлснээр дахин хэрэглэх боломжийг бий болгож буй юм.

2018 оны эхний хагас жилийн байдлаар 80 ажилтан, 659 сая төгрөгийн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ хугацаанд 6 сая шил цуглуулсан байна.



НАТУР АГРО ХХК

Натур Агро ХХК-нь 2012 онд байгуулагдсан өдөрт 32,500 литр альфа спирт үйлдвэрлэх хүчин чадалтай орчин үеийн бүрэн автоматжсан спиртийн үйлдвэр юм. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 19.1 тэрбум төгрөгний хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.



УЛААНБААТАР СПИРТ ХХК

Улаанбаатар Спирт ХХК-нь 2002 онд байгуулагдсан. Өдөрт 12,800 литр спирт үйлдвэрлэх хүчин чадалтай орчин үеийн спиртийн үйлдвэр юм. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 33 ажилтан, 3.8 тэрбум төгрөгний хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХК

АПУ ХК-нь 1924 онд байгуулагдсан ба архи спирт, шар айраг, ус ундааны үйлдвэрүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 703 ажилтантайгаар ажилласан ба 41.5 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Архины Үйлдвэр

Архины үйлдвэр нь 1972 оноос эхлэн ашиглалтанд орсон бөгөөд Герман, Австри, Итали, улсын шилдэг фирмүүдийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютер микропроцессын хяналтын удирдлага бүхий үйлдвэр юм. Жилд 200,000 гектолитр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.



Шар айргийн үйлдвэр

Анх 1927 оноос Чех улсын мэргэжилтний оролцоо тусламжтайгаар шар айраг үйлдвэрлэж эхлэсэн. 2013 онд шар айргийн үйлдвэрт барилга, шугам сүлжээ, техник, технологийн иж бүрэн шинэчлэлтийг хийж, Герман улсын KRONES компанийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Тус үйлдвэр жилдээ 1 сая хектолитр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.



Ус, ундааны үйлдвэр

Ус, ундааны үйлдвэр нь Европын Холбооны эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан дэлхийн нэртэй фирмүүд болох Австрийн Клингер, Германы Косме, Гернеп, Фамикс, италийн Самса Пак зэрэг бүрэн автомат тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. 2012 онд шинэ ПЭТ савлах шугамын төслийг Герман улсын KRONES компанитай хамтран хэрэгжүүлсэнээр үйлдвэрийн хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлсэн. Германы Грунбек компанийн ус цэвэршүүлэн шүүх системээр гүний усыг 4 давхар шүүлтүүрээр шүүн цэвэршүүлдэг





СПИРТ БАЛ БУРАМ ХХК

Спирт Бал Бурам ХХК-нь 1973 онд байгуулагдсан. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 295 ажилтан, 38.1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажиллаж 4.3 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.



М СИ ЭС АЗИА ПАСИФИК БРЮЭРИ ХХК

М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК-нь 2005 онд байгуулагдсан. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 256 ажилтан, 68.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажиллаж 11.5 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

APU DAIRY

Absolute. Pure. Unique.

АПУ ДЭЙРИ ХХК

АПУ Дэйри ХХК-нь 2017 онд байгуулагдсан. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 195 ажилтан, 52.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажиллан 8.8 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулжээ.

APU TRADING

Absolute. Pure. Unique.

АПУ ТРЕЙДИНГ ХХК

АПУ Трейдинг ХХК-нь 2007 онд байгуулагдсан. Борлуулалтын менежментийн чадварлаг баг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр АПУ групп компанийн бүтээгдэхүүний борлуулалтыг хариуцан ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар 485 ажилтантайгаар 4298 худалдааны цэгээр дамжуулан 39.9 сая литр бүтээгдэхүүн борлуулжээ.



СПИРТ БАЛ БУРАМ ТРЕЙД ХХК

Спирт Бал Бурам Трейд ХХК-нь 2001 онд байгуулагдсан. Борлуулалтын менежментийн чадварлаг баг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр АПУ групп компанийн бүтээгдэхүүнийг борлуулалтыг хариуцан ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар 155 ажилтантай байсан бөгөөд 19.6 сая литр бүтээгдэхүүн борлуулжээ.



ГРАНД ХХК

Гранд ХХК-нь 2012 онд Оросын холбооны улсын хуулийн дагуу байгуулагдсан. Борлуулалтын менежментийн чадварлаг баг хамт олны бүрэлдэхүүнтэйгээр АПУ групп компанийн ОХУ дахь борлуулалтыг хариуцан ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 6 ажилтан, 1.2 тэрбум төгрөгний хөрөнгөтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ БАГЦЫН ТАНИЛЦУУЛГА



АРХИ

ЧИНГИС ХААН



СОЁМБО



EVOK



VELVET



БОЛОР



ARKHI



EDEN



ЧИНГИС



ТИТЭМ



ТАЙГА



УЛААНБААТАР



VIVA



ОХЬ



ЕРӨӨЛ



СҮЛД



АЛТАН ТҮРҮҮ



САРХАД



Шар Айраг

ЧИНГИС ХААН



АЛТАН ГОВЬ



TIGER



HEINEKEN



PRIME



БОРГИО



НИЙСЛЭЛ



LEGEND



СЭРҮҮН



ХАР ХОРУМ



KALTENBERG



СЭНГҮР



СЭНГҮР РАДЛЕР



BLISS



ЖАЛАМ ХАР



Ус, ундаа

АПУ
Цэвэр ус



ОРГИЛУУН
Хийжүүлсэн ус



ТЭРЭЛЖ, СЭЛЭНГЭ
Хийжүүлсэн ундаа



ФРУТТА
Ундаа, жимсний шүүс



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

САЙН



МААМУУ



ДЭЭЖ



ЦЭВЭР СҮҮ



Импортын бүтээгдэхүүн

CINZANO

CINZANO



WILD TURKEY



APEROL

APEROL



CAMPARI

GRUPPO
CAMPARI



JÄGERMEISTER



ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 224 тоот тогтоолоор АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрсөн. Энэхүү тайланд 2018 оны хагас жилийн үр дүнг групп компаниар тайлагнасан болно.

2018 оны хагас жилийн байдлаар нийт 2,202 хүний бүрэлдэхүүнтэйгээр 278 нэр төрлийн 65 сая литр бүтээгдэхүүнийг борлуулж 201 тэрбум төгрөгийн орлого олж, 33.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Тайлант үеийн байдлаар улсын төсөвт нийт 120 тэрбум төгрөгийн татварыг төлсөн байна.

ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (сая.төгрөг)

85% ↑

2018Q2 201,278

2017Q2 108,443

ЦЭВЭР АШИГ (сая.төгрөг)

2 дахин ↑

2018Q2 33,697

2017Q2 15,948

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ (SKU)

66% ↑

2018Q2 278

2017Q2 167

БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ (мян.литр)

50% ↑

2018Q2 65,434

2017Q2 44,292

ТАТВАР ТӨЛӨЛТ (сая.төгрөг)

2 дахин ↑

2018Q2 120,021

2017Q2 60,767

АЖИЛЧДЫН ТОО (Хүн)

2.7 Дахин ↑

2018Q2 2,202

2017Q2 806

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БАГ



ТУЗ

ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 нь хараат бус гишүүн юм.

- Аудитын хороо
- Цалин урамшууллын хороо
- Нэр дэвшүүлэх хороотойгоор ажиллаж байна.




ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн дарга



KENNETH CHOO
ТУЗ-ийн ердийн гишүүн



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн



JASPER HAMAKER
ТУЗ-ийн ердийн гишүүн



ГАЛСАНГИЙН ГАНБОЛД
ТУЗ-ийн ердийн гишүүн



СЕРГЕЙ ГРОМОВ
ТУЗ-ийн ердийн гишүүн



ӨЛЗИЙДЭЛГЭРИЙН БАТБАЯР
Хараат бус гишүүн



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
Хараат бус гишүүн



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
Хараат бус гишүүн



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Инженер мэргэжилтэй.

1993-1996: Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал
1997-2008: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал
2002 оноос хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
2004-2008: АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал
2008 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч
2010 оноос хойш: Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



KENNETH CHOO
ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн

Нягтлан бодогч, менежмент боловсролтой (CA),

1992-1994: Ахлах аудитор, PWC
1997-2003: Бүс нутаг хариуцсан захирал/ Дэд ерөнхийлөгч, Royal Ahold/ CRC Ahold company
2003-2012: Бизнес хөгжил хариуцсан захирал, Heineken
2013-2015: Захирал/ Дэд захирал/ Бүс нутаг хариуцсан захирал, Heineken (APB, Singapore, Indochina)
2015 – одоог хүртэл: Захирал, Heineken Asia Pacific
2017.01.25-р сараас хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



БҮРЭНТОГТОХЫН БАТБЯАР
ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй.

1994-1996: МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш;
1999-2001: Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх;
2002-2012: Европын сэргээн босголт, хөгжлийн банкинд Ахлах мэргэжилтэн;
2012 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал;
2013 оноос хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



JASPER HAMAKER

ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүүгийн менежмент, эконометрикс мэргэжилтэй (CFA)

1990-1995: Jonge демократен, Netherlands

2003-2005: Санхүүгийн хяналт хариуцсан менежер, Nigerian Breweries/Heineken

2006-2010: Санхүүгийн захирал, PT Multi Bintang Indonesia Tbk

2010-2014: Санхүүгийн захирал, Nigerian Breweries/Heineken

2014-одоог хүртэл Бүс нутгийн санхүү хариуцсан тэргүүн захирал/Heineken

2017.01.25-р сараас хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ГАЛСАНГИЙН ГАНБОЛД

ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн

Инженер, эдийн засагч мэргэжилтэй.

1983-1990: МХЗЭ-ийн Төв хорооны Хэлтсийн эрхлэгч, Нарийн бичгийн дарга;

1991-1993: Монголын залуучуудын холбооны Тэргүүлэгч;

1998-2000: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Тэргүүн дэд дарга;

2000-2015: Голомт банкны Дэд ерөнхийлөгч, Газрын захирал, Тэргүүн дэд захирал;

2015-2016: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Дэд дарга;

2016 оноос хойш: Голомт банкны Ерөнхийлөгч;

2017 оны 3-р сараас хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



СЕРГЕЙ ГРОМОВ

ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн ердийн гишүүн

Инженер мэргэжилтэй.

1992-1994: ОХУ-ын "Разноимпорт" ХХК-д Менежер;

1994-2000: "Транс-ворлд Алюминум" компанийн Лондон дахь салбарын захирал;

2001-2016: Чингисхаан банкны ТУЗ-ийн дарга;

2006 оноос хойш: Монгол Даатгал компанийн ТУЗ-ийн дарга

2013 оноос хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ

Хараат бус гишүүн



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН

Хараат бус гишүүн



ӨЛЗИЙДЭЛГЭРИЙН БАТБАЯР

Хараат бус гишүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй.

1990-2000: Монгол банкинд эдийн засагч, хэлтсийн дарга, Ерөнхийлөгч

1996-2000: Азийн хөгжлийн банк, Монгол улсыг хариуцсан захирал

2000-2006: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал

2009-2015: Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал

2015 оноос хойш: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал, Ерөнхий нарийн бичгийн дарга

2013 оноос хойш: АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Үйлдвэрийн инженер, эдийн засагч мэргэжилтэй

1981-1989: МУИС, БДС, УАМДИ-д-д багш

1989-1991: Сайд нарын зөвлөлд референт

1991-1993: Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга

1993-1996: Үйлдвэрийн газрын Өөрчлөн байгуулалтын төвийн захирал

1996-2000: УИХ-ын гишүүн

2000-2006: ЗХАН-н ЕНБД, “Эх орон-Ардчилал” бүлгийн ажлын албаны дарга

2006-2008: Шадар сайдын ахлах зөвлөх

2008-2010: ХУД, ИТХ-ын ажлын албаны дарга

2010-2012: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга

2012-2016: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

2017 оны 3-р сараас хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Инженер, эдийн засагч мэргэжилтэй.

1998 оноос хойш: Баттур трейвэл ХХК-ийн Ерөнхий захирал;

2008 оноос хойш: Улаанбуудайн эх газар ХХК-ийн Ерөнхий захирал;

2014 оноос хойш: Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга;

2017 оноос хойш: Прокон майнинг Монгол-Канадын хамтарсан компанийн ТУЗ-ийн гишүүн;

2017 оны 6-р сараас хойш: АПУ ХК-ийн ТУЗ-н хараат бус гишүүн

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



УДИРДЛАГЫН БАГ

2017 онд Гүйцэтгэх захирлын дэргэд, түүнийг шийдвэр гаргахад зөвлөх, туслах чиг үүрэг бүхий гишүүдтэй Захирлын зөвлөлтэйгөөр ажилласан бол бизнесийн зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оноос АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал, Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Санхүү эрхэлсэн захирал, Стратеги эрхэлсэн захирал, Маркетинг эрхэлсэн захирал, Борлуулалт эрхэлсэн захирал, Хүний нөөц, захиргаа эрхэлсэн захирал, Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал, Экспорт эрхэлсэн захирал, Спирт Бал Бурам ХХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал болон АПУ Дэйри ХХК-ийн гүйцэтгэх захирал гэсэн удирдлагын багтайгаар ажиллаж байна.



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
АПУ Дэйри ХХК-н Гүйцэтгэх захирал



ХОУ ТЭЙК ПЭН
Үйлдвэрлэл, Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



ЯДАМДОРЖИЙН ДАМДИНСҮРЭН
Стратеги эрхэлсэн захирал



БАНЗРАГЧИЙН ТҮВШИН
Санхүү эрхэлсэн захирал



АРИУНАА ДАНДАРОВА
Маркетинг эрхэлсэн захирал



ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ
Борлуулалт эрхэлсэн захирал



ШИГИЛОВЫН ДӨЛГӨӨН
Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал



БАДРУГАНЫН НАРАНЗУН
Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал



ГАНБААТАРЫН ГАНЗОРИГ
Экспорт эрхэлсэн захирал



ГАНЖИЙН ГАНЗОРИГ
Спирт Бал Бурам ХХК-н
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал

Автоматикийн инженер, Бизнесийн удирдлага мэргэжилтэй.
1995-2000 : Говь ХК-ийн Инженер, худалдааны менежер, ахлах менежер
2000-2007: Эрдэнэт хивс ХК-ийн Гүйцэтгэх захирал
2007-2008 : АПУ ХК-ийн Дэд захирал
2008 оноос хойш: АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
АПУ Дэйри ХХК-н Гүйцэтгэх захирал

Нягтлан бодогч, Эдийн засагч , Бизнесийн удирдлага мэргэжилтэй.
1997-2001 : Аянга интернэшнл, Ерөнхий нягтлан бодогч
2002-2003: Санаа трейд ХХК, Ерөнхий нягтлан бодогч
2003-2006: АПУ Трейдинг ХХК, Санхүүгийн газрын дарга
2006-2008: АПУ ХК, Санхүүгийн газрын дарга
2008-2009: Капитал групп ХХК, Санхүү хариуцсан захирал
2011-2012: АПУ ХК, Санхүү хариуцсан захирал
2012-2017: АПУ ХК, Үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан захирал
2017.11 сараас хойш: АПУ Дэйри ХХК, Гүйцэтгэх захирал



ХОУ ТЭЙК ПЭН
Үйлдвэрлэл, Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

Исгэлтийн технологич, Механикийн инженер мэргэжилтэй.
1987-1992: Carnaud Metalbox, Төслийн менежер, Сингапур улс
1992-1996: Asia Pacific Breweries, Тоног төхөөрөмжийн ашиглалтын менежер, Сингапур улс
1996-1998: Myanmar Brewery, Сургалтын менежер, Мянмар улс
1998-2002: Cambodia Brewery, Ерөнхий инженер, Камбож улс
2002-2005: Myanmar Brewery, Шар айрагны үйлдвэрийн менежер, Мянмар улс
2005-2008: South Pacific Breweries, Техник хариуцсан менежер, Papua New Guinea улс
2008-2014: Cambodia Brewery, Үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежер, Камбож улс
2014-2016: Heineken Asia Pacific, Бүс хариуцсан үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежер
2016-2017: AB Heineken Philippines, Үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан захирал, Филиппин улс
2017-2018: M Bi Si, Үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан захирал
2018 оноос хойш : АПУ ХК, Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал



ЯДАМДОРЖИЙН ДАМДИНСҮРЭН
Стратеги эрхэлсэн захирал

Эдийн засагч , Маркетингийн удирдлага мэргэжилтэй.
1994-1996: Сангийн яам, Улсын төсөв хариуцсан ажилтан
1996-1998: Мон-Сам ХХК, Санхүү хариуцсан захирал
2000-2004: Апекс ХХК, Гүйцэтгэх захирал
2008-2017: М Би Си, Санхүү хариуцсан захирал
2017-2018: М Би Си, Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш: АПУ ХК-ийн Стратеги эрхэлсэн захирал



БАНЗРАГЧИЙН ТҮВШИН
Санхүү эрхэлсэн захирал

Нягтлан бодогч, Эдийн засагч, Олон улсын бизнесийн удирдлага, Хуульч мэргэжилтэй.
1997-1999: Худалдаа хөгжлийн банк, Эдийн засагч
1999-2003: Эрэл ХХК, Ахлах нягтлан бодогч
2003-2011: АПУ ХК, Санхүүгийн газрын дарга
2011-2017: АПУ ХК, Санхүү хариуцсан захирал
2017 оноос хойш : АПУ ХК, Санхүү эрхэлсэн захирал



АРИУНАА ДАНДАРОВА
Маркетинг эрхэлсэн захирал

Хэл шинжлэлийн ухаан, Бизнесийн удирдлага мэргэжилтэй.
1998-2000: Robertson & Blums Corporation, Захиргааны менежер
2000-2003: Biletik, Ерөнхий менежер
2005-2006: АПУ ХК, Маркетингийн албаны дарга
2006-2014-: АПУ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны дарга
2014-2017: АПУ ХК, Харилцаа, инноваци хариуцсан захирал
2018 оноос хойш : АПУ ХК, Маркетинг эрхэлсэн захирал



ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ
Борлуулалт эрхэлсэн захирал

Япон хэлний орчуулагч, Бизнесийн удирдлага мэргэжилтэй.
2008-2009: АПУ Трейдинг ХХК, Брэнд менежер
2009-2015: АПУ Трейдинг ХХК, Маркетингийн албаны дарга
2015-2017 : АПУ Трейдинг ХХК, Борлуулалт болон Маркетинг хариуцсан захирал
2018 оноос хойш : АПУ ХК, Борлуулалт эрхэлсэн захирал



ШИПИЛОВЫН ДӨЛГӨӨН
Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал

Эрчим хүчний удирдлага мэргэжилтэй.
2008-2010: М-Си-Эс Дистрибушн ХХК, Хүний нөөцийн ажилтан
2011-2012: СББ Трейд ХХК, Хүний нөөцийн ахлах ажилтан
2012-2014: М Би Си, Сургалт хөгжил хариуцсан менежер
2014-2015: М Би Си, Захиргаа, хүний нөөцийн менежер
2016-2017: М Би Си, Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал
2018 оноос хойш : АПУ ХК, Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал



БАДРУУГАНЫН НАРАНЗУН
Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал

Урлаг судлаач мэргэжилтэй.
2007-2009: Соёл Урлагийн Их Сургууль, Багш
2010-2012: БСШУЯ, Соёл Урлагийн газрын дарга
2014-2016: Шунхлай групп, Байгууллагын харилцаа хариуцсан захирал, АПУ ХК, Төслийн удирдагч
2016-2017: АПУ ХК, Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал
2018 оноос хойш : АПУ ХК, Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал



ГАНБААТАРЫН ГАНЗОРИГ
Экспорт эрхэлсэн захирал

Олон улсын харилцаа мэргэжилтэй.

2004-2005 : UMB банк , Теллер

2005-2007, 2009-2010 : Хаан банк, Харилцаа хариуцсан менежер

2010-2012 : Хадгаламж банк, Харилцааны хэлтсийн дарга

2015-2017 : М-Би-Си ХХК, Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал

2018 оноос хойш: АПУ ХК, Экспорт эрхэлсэн захирал



САНЖИЙН ГАНЗОРИГ
Спирт Бал Бурам ХХК-н
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

Эдийн засагч мэргэжилтэй.

2001-2002 : М-Си-Эс Кока Кола ХХК, Худалдааны төлөөлөгч

2002-2004 : М-Си-Эс Кока Кола ХХК, Түгээлтийн менежер

2004-2005: СББ Трейд ХХК , Борлуулалтын менежер

2005-2007: СББ Трейд ХХК, Орон нутгийн борлуулалтын албаны дарга

2007-2010: М-Си-Эс Дистрибьюшн, Ложистик хариуцсан захирал

2010-2014: СББ ХХК, Гүйцэтгэх захирал

2014 оноос хойш : М-Би-Си, /Зүүн хараа/, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

2018 оноос хойш : АПУ ХК, /Зүүн хараа/, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нийт өр төлбөр 18%-иар буурсан нь Кредит Суиссе-с авсан зээлийг урьдчилан төлж барагдуулсантай холбоотой.


Балансын бүтцийн хувьд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн бүтэц төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд нийт өр төлбөр буюу зээл буурсантай холбоотой эздийн өмчийн эзлэх хувь 84% болж өссөн байна

Санхүүгийн байдал

	2017Q2	2018Q2 /АПУ ХК-ийн тусдаа санхүүгийн тайлан/
Эргэлтийн хөрөнгө	91,460	80,170
Эргэлтийн бус хөрөнгө	188,599	529,638
Нийт актив	280,058	609,809
Өр төлбөр	121,666	99,517
Эздийн өмч	158,392	510,292
Нийт пассив	280,058	609,809

2018Q2 /АПУ ХК-ийн нэгтгэсэн удирдлагын тайлан/
176,527
449,215
625,742
98,028
527,714
625,742

Санхүүгийн байдал



Нэгтгэсэн удирдлагын тайлангийн тайлбар

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.4-т заасны дагуу толгой компани нь зөвхөн жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн хүргүүлэх үүрэгтэй байдаг. Энэхүү танилцуулгад дурьдсан нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүд нь компанийн шийдвэр гаргалтыг дэмжих үүднээс бэлтгэсэн тайлангийн хэсэг болно.

ОРЛОГО ҮР ДҮН

Нэгдлийн эерэг нөлөөллийн үр дүнд EBITDA маржин өмнөх оны мөн үеэс 3%-аар өссөн үзүүлэлтэй байна.

Орлого үр дүн

	2017Q2	2018Q2 /АПУ ХК-ийн тусдаа санхүүгийн тайлан/	2018Q2 /АПУ ХК-ийн нэгтгэсэн удирдлагын тайлан/
Цэвэр борлуулалтын орлого	108,443	99,476	201,278
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	75,565	64,508	86,333
Нийт ашиг	32,878	34,967	114,944
Үйл ажиллагааны зардал	(17,119)	(14,370)	(70,470)
Үйл ажиллагааны ашиг	15,759	20,597	44,474
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	5,214	(3,183)	(2,086)
Татвар төлөхийн өмнөх ашиг	20,973	17,414	42,387
Татварын зардал	(5,024)	(3,562)	(8,691)
Татварын дараах ашиг	15,948	13,852	33,697
EBITDA	28,388	27,857	57,682
Үйл ажиллагааны ашгийн маржин	15%	21%	22%
Цэвэр ашгийн маржин	15%	14%	17%
EBITDA маржин	26%	28%	29%

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2018 оны 2-р улиралд Кредит Суиссе-с авсан зээлийг урьдчилан төлөн нийт 15.3 сая доллар буюу 36.8 тэрбум төгрөгийн зээлийг барагдуулсан. Сүүлийн хагас жилд үлдсэн зээлийг төлөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зээлийн мэдээ	Валют	Зээлийн эхний үлдэгдэл 2018.01.01	Зээлийн төлөлт	Зээлийн эцсийн үлдэгдэл 2018.06.30
Кредит Суиссе	сая доллар	11,074	11,074	
Европын сэргээн босголтын банк	сая доллар	17,091	4,273	12,818
Нийт	сая доллар тэрбум төгрөг	28,165 68,360	15,347	12,818 31,569
USD ханш		2,427.13		2,462.82

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Нэгтгэх замаар өөрчлөгдөн байгуулагдаж, стратегийн хөрөнгө оруулагчдад зориулж хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргаж, үнэт цаасны төлбөрт ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг өрсөлдөгч компаниудын хувьцааг авсан. Сингапур улсад бүртгэлтэй Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд (Спирт бал бурам ХХК, СББ Трейд ХХК, М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК-ийн толгой компани), АПУ трейдинг ХХК, Улаанбаатар спирт ХХК, Депод ХХК, Натур агро ХХК-ийн хувьцааг 100% эзэмшигч Эвэргрийн Инвестментс ХХК нь АПУ ХК-д нэгдэж, ийнхүү нэгдсэний төлбөрт АПУ ХК-аас нэмж хувьцаа гаргаж Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигч болох Хайнекен Азия Пасифик Пте. Лтд, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нарт эзэмшүүлсэн. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсаныг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Хувьцаа эзэмшигчид / 2018.07.03-ны байдлаар /


	Эзэмшлийн %
Туул интернейшнл ХХК	36%
Хайнекен Азия Пасифик Пти.Лтд	25%
Вит Альянс Лимитэд	14%
Голомт банк	13%
Монголиан Бэвэриж Инвестмент ХХК	5%
Бусад	6%
Нийт	100%

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА, ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Стратегийн хөрөнгө оруулагчтай хамтрах зорилгоор АПУ ХК нь нэгдлийн үйл ажиллагааг 2017 оны эхнээс эхлүүлсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/199 тоот тушаалаар АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Ингэснээр АПУ ХК-ийн зах зээл дэх хувьцааны тоо 1,064,181,553 ширхэг болсон юм.

АПУ ХК-ийн хувьцаа 2018 оны 2-р улирлын байдлаар нийт 7,264 мянган ширхэг буюу 4,7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тоо хэмжээгээр 4 дахин өсөлт хийж, үнийн дүнгээр 8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Харин хувьцааны ханшийн хувьд 6 сарын 30-ны байдлаар 633 төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 118%-аар өсөж, оны эхэн үетэй харьцуулахад 12%-ийн бууралт үзүүлсэн. АПУ ХК-ийн хувьцаа Монголын хөрөнгийн биржээс тогтоодог идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны 3 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

	2017Q2	2017Q4	2018Q2
Хаалтын ханш, төгрөг	290.3	716.7	633.39
Нийт арилжаалагдсан хувьцаа	1,804.7	13,813.4	7,264.0
Нийт арилжааны дүн, сая төгрөг	574.2	8,458.6	4,739.6
Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг	214.96	762.70	674.04



НОГДОЛ АШИГ

АПУ ХК нь 2006–2017 онд буюу нийтдээ 11 жилийн хугацаанд 38.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг зарлажээ. 2017 онд манай компани нийт 10.6 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа 10 төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашиг

	Ногдол ашиг тараасан хувьцаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Нийт ногдол ашиг /сая.төг/
2006 он	742,877	60	45
2007 он	742,877	538	400
2008 он	74,287,700	10	743
2009 он	74,167,019	20	1,483
2010 он	74,167,019	40	2,967
2011 он	74,167,019	60	4,450
2012 он	74,167,019	70	5,192
2013 он	74,167,019	90	6,675
2014 он	74,167,019	-	-
2015 он	74,167,019	70	5,192
2016 он	741,167,019	1	742
2017 он	1,064,181,553	10	10,642